

- 2007 оны 9-р сарын 7-12 өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Хүн байгаль орчинд халгүй үр дүнтэй түншлэл” сэдэвт олон улсын бага хуралд БУХноос 10 хүн оролцож, олон орны туршлагаас суралцаж, БУХ-ны гишүүн Лхагва “Орон нутгийн хувиараа ашигт малтмал олборлогчдийн хөгжил, чиг хандлага” танилцуулгыг хийсэн.
- 2008 оны 10-р сарын 02-06 өдрүүдэд Бразиль улсад зохион байгуулсан бичил уурхайчдийн 8-р бага хуралд БУХ-ны тэргүүн “Бичил уурхайн үүсэл хөгжил, эрх зүйн орчин зохицуулалт” сэдвээр танилцуулга хийж өөрсдийн үйл ажиллагааг сурталчилан, бусад орны туршлага судлан орон нутагтаа таниулаж байна.
- Засгийн газраас гаргасан түр журмын дагуу ХАМО иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтанд шилжүүлэхэд ажлаа чиглүүлж байна. Одоогийн байдлаар 35 нөхөрлөлийн 114 гишүүнтэй болоод байна.

Цаашид төлөвлөж буй ажлууд:

- Нөхөрлөллийн тоог 50, гишүүдийн тоог 300 хүргэх
- Олборлолт явуулах газрын гэрээг байгуулах, уулын ажлыг зохион байгуулах
- Уулын ажлын төлөвлөгөөг хийж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтанд гишүүдээ хамруулах
- Удирдах зөвлөл болон дэд зөвлөлүүдийн гишүүдийг чадвархижуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Үйл ажиллагаагаа нээлттэй сурталчилах
- Орон нутгийн нөөц баялаг, уул уурхайн нөхцөл боломж, ажиллах хүчний нөөцөө судлан тодорхойлж, бодит боломж давуу талаа бичил уурхайн хэлбэрээр үр дүнтэй ашиглах, бичил уурхайн стандартыг тогтоон мөрдөхөд чиглүүлэн ажиллах

Хамтран ажилладаг байгууллагууд:

- Швейцарийн Хөгжлийн Агентлаг, ТоБУТ: ТоБУТ Бичил уурхайчдын холбоо ТББ үйл ажиллагааг эхнээс нь дэмжин манлайлалыг идэвхжүүлэх, ХАМО иргэдэд бичил уурхайн хөгжлийн төлөвийг таниулан сурталчилах, ХАМО - ийг чадвархижуулах, төрийн захиргааны болон хууль тогтоох байгууллага, бусад холбогдох талуудын мэдээлэл солилцоо, гэрээ хэлцэл зуучлах, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, техник технологийн туршилт сонголт, сургалт, зөвлөгөө чиглэл өгөх зэргээр хамтран ажиллаж байна.
- “ХАМО” ХХ Компани нь Холбооны гишүүдийн үүсгэл санаачилгаар ХАМО нөхөрлөлүүдийн олборлосон хүдрийг боловсруулах зорилгоор байгуулагдсан.



Манай хаяг:

“Бичил Уурхайчдын Холбоо”

Төв аймаг, Борнуур сум,
36 айлын орон сууцны баруун зах
Утас: 9916 7504
8809 0631
9996 9090



“БИЧИЛ УУРХАЙЧДЫН ХОЛБОО”
Төрийн бус байгууллага

ТАНИЛЦУУЛГА



**Тогтвортой
бичил уурхай
төсөл**

“БИЧИЛ УУРХАЙЧДЫН ХОЛБОО” ТББ

Холбооны үүсэл:

Төв аймгийн Борнуур сумын хувиараа алт олборлогч хэсэг иргэдийн санаачилгаар “Бичил Уурхайчдын Холбоо” ТББ нь 2007 оны 11-р сарын 30-нд хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эрх ашгийг төлөөлөх анхны төрийн бус байгууллага (ТББ) байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.



Холбооны зорилго:

“Хувиараа ашигт малтмал олборлогч (ХАМО) иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, өөрсдийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, ажлын байр орлогоо хууль эрх зүйн хүрээнд баталгаажуулах, орон нутгийнхаа нөөц баялаг, уул уурхайн боломж нөхцөл, ажиллах хүчний нөөцөө түшиглэн бичил уурхайн хөгжлийн загварыг бий болгож сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах” хэмээн тодорхойлсон.



БУХ-ны бүтэц зохион байгуулалт:

Бичил Уурхайчдын Холбооны (БУХ) Удирдах Зөвлөл (УЗ) 7 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилдаг. Хяналтын Зөвлөл (ХЗ) 5 гишүүний бүрэлдэхүүнтэй. дарга: Ч. Мөнхсайхан ХЗ-ийн гишүүд: Б. Мөнхзул, Х. Чалхаа, Д. Тайван, Б. Отгонбаатар БУХ-ны тэргүүн: Р. Цогбадрах, БУХ-ны орон нутгийн идэвхижүүлэгч: Р. Түмэндэмбэрэл. БУХ гишүүддээ үйлчилдэг Төрийн Бүс Байгууллага.

БУХ-ны дэргэд техникийн, нийгмийн, байгууллагын хөгжлийн дэд зөвлөлүүд байгуулагдан ажиллаж байна.

Нийгмийн дэд зөвлөл:

5 гишүүнтэй. Нийгмийн дэд зөвлөлийн үндсэн үүрэг роль: ХАМО нарт тулгарч буй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллах. Үүнд: эрүүлд мэнд, хуримтлал бий болгох, ажлын нөхцөл байдлыг сайжруулах, бусад орлогын эх үүсвэрийг олох гэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх

Байгууллагын хөгжлийн дэд зөвлөл:

5 гишүүнтэй. Байгууллагын хөгжлийн дэд зөвлөлийн үндсэн үүрэг роль: БУХ-г хучирхэг байгууллага болгоход дэмжлэг үзүүлж ажиллах. Үүнд: санхүү, хүний нөөц, хамтын ажиллагааг сурталчилах, гишүүдийн бүртгэл, БУХ-ны үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ зэрэг асуудлыг хариуцан ажиллах.

Техникийн дэд зөвлөл:

38 гишүүнтэй, нөхөрлөл бүрээс нэг хүн. Техникийн дэд зөвлөлийн үндсэн үүрэг роль: нөхөрлөлүүд болон гишүүн бүр хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг бичил уурхайн үйл ажиллагаандаа мөрдөх.



БУХ-ны гишүүнчлэл:

“Бичил уурхайчдийн холбоо”-нд гишүүнээр бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлж буй хүн бүр, сайн дурын үндсэн дээр хамтран нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон нөхөрлөл, түүний гишүүд элсэх боломжтой.

Холбооны үйл ажиллагааны товч мэдээлэл:

- “Борнуур мөнгөн усгүй амьдрал” олон талт зөвлөгөөнийг “Тогтвортой бичил уурхай” төслийн (ТоБУТ) дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Зөвлөгөөний үр дүнд мөнгөн усгүй технологиор хүдэр боловсруулах үйлдвэрийн төсөл дэмжигдэж эхний туршилтын цех ашиглалтанд ороод ажиллаж байна.
- УИХ-ын гишүүдийн идэвхтэй оролцоо, Швейцарийн хөгжлийн агентлаг, ТоБУТ-ийн туслалцаа дэмжлэгтэйгээр “Олон талт хамтын ажиллагааны” 5 талын гэрээнд гарын үсэг зурагдсан байгаа. Үг гэрээнд “Сентерра Гоулд Монголиа” компани нь өөрийн 194 А (Сүжигт) лизензтэй талбайгаас Борнуурын ХАМО иргэдэд тодорхой хугацаанд бичил уурхайн зориулалтаар олборлолт явуулах боломжийг олгоно. Гэхдээ энэ боломжийг олгоход МУ-ын ЗГ, Борнуур сумын засаг захиргаа нь “Сентерра Гоулд Монголиа” тал хүлээн зөвшөөрсөн байх гэрээг байгуулна гэж тусгагдсан байгаа.

